



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/996

Мандалговь

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйл 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3, 16.1.8, 16.3.10, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар хэсгийн 2.1.4 дэх заалтууд болон аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 04 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэрэн сумын уугуул, Улсын Филармонийн Баянмонгол чуулгын ерөнхий удирдаач, Монгол Улсын Төрийн соёрхолт, Урлагийн Гавьяат зүтгэлтэн Бадамдоржийн Ганбат агсны 70 насны ойд зориулан түүний шилдэг уран бүтээлийн пянзыг гаргахад хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах 5,000,000 (Таван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Л.Доржбат), нягтлан бодогч (М.Янжиндолгор) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ

4823100776